ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2021/148/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn
Аудитор: Л.Равдандорж
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn



Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 11

3. Аудитын тайлан ........ 12

3.1. Ерөнхий зүйл ........ 12

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 12

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 13

3.4. Материаллаг байдал ........ 13

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 13

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 14

3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 15

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

3.9. Аудитын илрүүлэлт ........ 15

Залруулсан алдаа ........ 16

Аудитын зөвлөмж ........ 16

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 16

4. Менежментийн захидал ........ 16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 18

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021. 02. 16 № 1-6/152

танай ____________-ны №____________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТСИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Ц.НЯМСҮРЭН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18989022.26** | **16782709.00** |
| **33** | **АВЛАГА** | 554500.26 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 554500.26 | 0.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 554500.26 | 0.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 4600000.00 | 0.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 4600000.00 | 0.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 4600000.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13834522.00 | 16782709.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 0.00 | 579000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 0.00 | 579000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 13834522.00 | 16203709.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4396825.00 | 3861810.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4935793.00 | 6973737.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4501904.00 | 5368162.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **191387743.81** | **207709191.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 191387743.81 | 207709191.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 184448795.19 | 202056409.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 161839780.06 | 166439780.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -3096827.64 | -7484000.13 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 50634574.47 | 68134574.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -50634574.47 | -52092907.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 41429848.55 | 47604688.05 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18123860.34 | -22365275.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5567542.00 | 4483042.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3167687.44 | -2663492.52 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6938948.62 | 5652782.14 |
| 39301 | Программ хангамж | 7297692.31 | 7297692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5878743.69 | -7164910.17 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5520000.00 | 5520000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **210376766.07** | **224491900.25** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **46666.62** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 46666.62 | 0.00 |
| **413** | **Өглөг** | 46666.62 | 0.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 46666.62 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 46666.62 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **210330099.45** | **224491900.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 210330099.45 | 224491900.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5520000.00 | 5520000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 5520000.00 | 5520000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 204810099.45 | 218971900.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 204810099.45 | 204810099.45 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 14161800.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **210376766.07** | **224491900.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **150344020.00** | **166293500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **112420.00** | **22878900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 112420.00 | 22878900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 112420.00 | 22878900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 112420.00 | 22878900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150231600.00** | **143414600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 150231600.00 | 140238800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 150231600.00 | 140238800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 3175800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 3175800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **148255011.47** | **152131699.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **148255011.47** | **152131699.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 147755011.47 | 150531681.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98362295.31 | 99403916.19 |
| 210101 | Үндсэн цалин | 64665321.61 | 69057592.77 |
| 210102 | Нэмэгдэл | 33691973.70 | 30346323.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5000.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3227546.77 | 1888600.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3227546.77 | 1888600.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12078000.00 | 14878000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1111054.65 | 1671999.92 |
| 210302 | Түлш, халаалт | 10407945.35 | 12445000.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 559000.00 | 761000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15272103.00 | 12843813.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2456548.00 | 2497401.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5556350.00 | 5687100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2570792.00 | 2308746.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89272.00 | 132900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2011173.00 | 1503056.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2587968.00 | 714610.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 1800000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 1800000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4857530.00 | 1746800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4857530.00 | 1746800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1944000.00 | 415000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1944000.00 | 415000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1217100.00 | 1597000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324000.00 | 540000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 72600.00 | 303000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50000.00 | 50000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 764500.00 | 654000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6000.00 | 50000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10796436.39 | 15958552.56 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10796436.39 | 15958552.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 500000.00 | 1600017.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500000.00 | 1600000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500000.00 | 1600000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.00 | 17.40 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 17.40 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2089008.53** | **14161800.80** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2089008.53** | **14161800.80** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **150231600.00** | **143414600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150231600.00** | **143414600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 150231600.00 | 140238800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 150231600.00 | 140238800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 3175800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 3175800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **150231600.00** | **137524600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **150231600.00** | **137524600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **149731600.00** | **135924582.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 97887000.00 | 98488100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 71241000.00 | 72289300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 26146000.00 | 25698800.00 |
| 210104 | Урамшуулал | 500000.00 | 500000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4108900.00 | 2296582.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4108900.00 | 2296582.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12078000.00 | 14878000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1111054.65 | 1671999.92 |
| 210302 | Түлш, халаалт | 10205945.35 | 12445000.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 761000.00 | 761000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12352600.00 | 11165600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2498313.00 | 1453900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5556350.00 | 5687100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3068692.00 | 2623200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89272.00 | 132900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1139973.00 | 1268500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 1800000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 1800000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18944000.00 | 10076800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5844000.00 | 6150000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13100000.00 | 3926800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1944000.00 | 415000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1944000.00 | 415000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1217100.00 | 1707500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324000.00 | 540000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 72600.00 | 303000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50000.00 | 50000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 764500.00 | 764500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6000.00 | 50000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1200000.00 | 987000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 700000.00 | 664000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500000.00 | 323000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **500000.00** | **1600017.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500000.00 | 1600000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500000.00 | 1600000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 17.40 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 17.40 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **5890000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **5890000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 5890000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-5890000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -19,754,212.47 | -19,754,212.47 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 19,754,212.47 | 0.00 | 19,754,212.47 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 688,108.53 | 688,108.53 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,520,000.00** | **0.00** | **204,810,099.45** | 210,330,099.45 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 14,161,800.80 | 14,161,800.80 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,520,000.00** | **0.00** | **218,971,900.25** | 224,491,900.25 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 140238800.00 | 140238782.60 | 17.40 | 100.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 140238800.00 | 140238782.60 | 17.40 | 100.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 138638800.00 | 138638782.60 | 17.40 | 100.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98488100.00 | 98488100.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 72289300.00 | 72289300.00 | 0.00 | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25698800.00 | 25698800.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 500000.00 | 500000.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2296600.00 | 2296582.60 | 17.40 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2296600.00 | 2296582.60 | 17.40 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14878000.00 | 14878000.00 | 0.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1672000.00 | 1671999.92 | 0.08 | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12445000.00 | 12445000.08 | -0.08 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 761000.00 | 761000.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11165600.00 | 11165600.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1453900.00 | 1453900.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5634300.00 | 5687100.00 | -52800.00 | 100.94 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2663200.00 | 2623200.00 | 40000.00 | 98.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 132900.00 | 132900.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1281300.00 | 1268500.00 | 12800.00 | 99.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1800000.00 | 1800000.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1800000.00 | 1800000.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6901000.00 | 6901000.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6150000.00 | 6150000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 751000.00 | 751000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 415000.00 | 415000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 415000.00 | 415000.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1707500.00 | 1707500.00 | 0.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540000.00 | 540000.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 303000.00 | 303000.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50000.00 | 50000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 764500.00 | 764500.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50000.00 | 50000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 987000.00 | 987000.00 | 0.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 664000.00 | 664000.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 323000.00 | 323000.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1600000.00 | 1600000.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1600000.00 | 1600000.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1600000.00 | 1600000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 140238800.00 | 140238782.60 | 17.40 | 100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 140238800.00 | 140238782.60 | 17.40 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 140238800.00 | 140238782.60 | 17.40 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3175800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3175800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3175800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3175800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3175800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3175800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3175800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3175800.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Нямсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд цалингийн тооцооллыг холбогдох дүрэм, журамд заасны дагуу маягт, аргачлалыг баримтлан ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-аас 2021 оны 01 дүгээр сарын 22–ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгон шинэчлэн баталж, мөрдүүлэх,
- Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн биелэлтийг эрчимжүүлж, бодит үр дүнд хүргэн дүгнэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;

- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 152,131.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,521.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,169.9 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 554.5 | 0.0 | -554.5 |
| Урьдчилгаа | 4,600.0 | 0.0 | -4,600.0 |
| Бараа материал | 13,834.5 | 16,782.7 | 2,948.2 |
| Үндсэн хөрөнгө | 272,289.4 | 299,479.8 | 27,190.4 |
| **Нийт хөрөнгө** | 210,376.7 | 224,491.9 | 14,169.9 |
| Өр төлбөр | 46.6 | | -46.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 210,330.0 | 224,491.9 | 14,169.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 210,376.7 | 224,491.9 | 14,169.9 |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь байгууллагаас авах авлага буюу НДХ-ээс авах авлагыг тайлант онд барагдуулж 554.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 4,600.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд урьдчилан төлсөн автомашины гадна талбайн барилгын ажил хийгдэж дуусан үндсэн хөрөнгөөр бүртгэж авсан нь шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16,782.7 мянган төгрөг болж 2,948.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 579.0 мянган төгрөг, аж ахуйн материал 2,037.9 мянган төгрөг, бусад хангамжийн материал 866.2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Энэ нь 2020 онд ШШГЕГ болон анги салбараас 1,088.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн бараа материалын орлогоос шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 299,479.7 мянган төгрөг болж 16,321.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн данс, урсгал төсвийн худалдан авалтаар 5,890.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 21,790.0 мянган төгрөг, данс хооронд шилжүүлэх зөвшөөрлийн дагуу үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа данснаас барилга байгууламж, орон сууц дансанд 4,600.0 мянган төгрөгийг шилжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй, 5,089.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө буюу машин тоног төхөөрөмж данснаас 4,005.1 мянган төгрөг, тавилга, эд хогшил данснаас 1,084.5 мянган төгрөгийг тус тус актласан, тайлант онд элэгдлийн зардал 15,958.6 мянган төгрөгөөр байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 46.6 мянган төгрөгөөр буурсан ХАОАТ 2019 онд өглөг үүссэнийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 224,491.9 мянган төгрөг болж 14,169.9 мянган төгрөгөөр өссөн нь 14,161,8 тайлант үеийн үр дүн бий болсноос шалтгаалжээ.

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,949.5 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 15,949.5 мянган төгрөгөөр өссөн байгаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оныхоос 22,766.5 мянган төгрөгөөр өссөн болон нэмэлт санхүүжилтийн орлого 3,175.8 мянган төгрөгийн орлого зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 3,876.7 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшлын зардал, норматив зардал, томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмсэн мөн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 143,414.5 мянган төгрөгөөр, зарлагыг 143,414.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 140,238.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 100 хувь урсгал зардалд санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 140,238.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 140,238.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын тамгын газраас 3,175.8 мянган төгрөгийн дэмжлэгийг авч байгууллагын архивын өрөөний засварын ажилд 100 хувь зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 554.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 554.5 | 1 | 554.5 | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | | | |
| Нийт дүн | 2 | 554.5 | 2 | 554.5 | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,114.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,037.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 30.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 47.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй ашиглагдаж байгаа 1,862.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байсныг залруулсан.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд Дорноговь аймгийн засаг дарга хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас хуваарилсан 3,175.8 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайланд өөр эх үүсвэр дээр тайлагнасан байсныг залруулсан.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь санхүүгийн тооцооллыг батлагдсан заавар, маягтын дагуу бүрэн хөтөлж ажиллахгүй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Цалингийн тооцоололтой холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт: Цалингийн урьдчилгаа олгосон боловч тооцооллыг цалингийн хавтгайд тусгаагүй байна.*

1.2. *Эрсдэл: Цалингийн хавтгайд тооцооллыг бүрэн тусахгүй байгаа нь ажилчидтай өглөг, авлагын тооцоо үүсэх мөн цалингийн залилантай холбоотой асуудал үүсэх эрсдэлтэй байна.*

1.3. *Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Аж ахуйн нэгж байгууллага нь НББ-ийн жинхэнэ хэрэгжилт, хэмжигдэхүйц, үнэн зөв байх зэрэг зарчмыг баримтлах тул цаашид цалингийн тооцооллыг хавтгайд бүрэн тусгаж холбогдох дүрэм, журмаар батлагдсан аргачлал зааврын дагуу бүртгэл маягтыг хөтлөх.*

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| **2021** | ***2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | дга-2021/148/ста-тшз |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс | Мянган төгрөг |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зөрүү тооцсон бодолтыг цалингийн хавтгайд бүрэн оруулдаггүй байна. Үүссэн цалингийн тооцоог урьдчилгаа цалин олголтоор залруулж ажилласан байна. | 0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Ц.Нямсүрэн, Н.Далайжаргал |
| 2 | ЖА тэтгэмж бодогдсон ажилтны цалингийн дунджийг тооцохдоо 6 сарын цалингаас дундаж тооцсон байна. | 30.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | Ц.Нямсүрэн, Н.Далайжаргал |
| 3 | Ажилтны ээлжийн амралтын цалингийн дунджийг тооцохдоо программаас алдаатай гарсан ажилласан хугацааны хоногоос дунджийг тооцсон | 47.1 | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | Ц.Нямсүрэн, Н.Далайжаргал |
| **ДҮН** | | **77.1** | | | |